



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

### Нийслэлийн хүүхдийн 152 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,810,000.00 (найман сая найман зуун арван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн хүүхдийн 123 дугаар цэцэрлэгийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн хүүхдийн 152 дугаар цэцэрлэг (С.Пүрвээ)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн хүүхдийн 123 дугаар цэцэрлэг (Э.Оюунгэрэл)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06-р дүгээр сарын 10-ны өдрийн А/Ч/6-дугаар тушаалын хавсралт

**БАЛАНСААС БАЛАНСТ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Байгууллага: Налайх дүүргийн 152-р цэцэрлэг

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2025 оны 06-р сарын 31-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Монгол гэр /иж бүрэн/	2014.12.31	ш	2	4,405,000.00	8,810,000.00	8,810,000.00	-	152-р цэцэрлэг	123-р цэцэрлэг
	Дүн			2	4,405,000.00	8,810,000.00	8,810,000.00	-		